



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 1/381

Арвайхээр


┌ Сургалтын байгууллага үүсгэн байгуулах ┐
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "б", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2020 оны 174 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Арвайхээр суманд шинээр баригдсан 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг 14 дүгээр цэцэрлэгээр үүсгэн байгуулсугай.

2.Арвайхээр сумын 14 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг 2020 оны 09 дүгээр сарын 30-ны дотор хийж, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, тусгай зөвшөөрөл авахад шаардагдах материалыг хуулийн дагуу бүрдүүлэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), Арвайхээр сумын Засаг дарга (О.Пүрэвдорж)-д тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100853